

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2011 ОНЫ 2 ДУГААР
УЛИРАЛД ИРҮҮЛСЭН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2011.09.09

Улаанбаатар хот

НЭГ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ ИРЦИЙН ТАЛААР:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1 дэх заалтыг үндэслэн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 02 дугаар сарын 28 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д 7 заалт бүхий 2.6 дахь хэсгийг болон гадаад валютын арилжааны мэдээ гаргах хавсралтуудыг тус тус шинээр нэмж, “Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа” эрхлэн явуулдаг ББСБ-ууд эдгээр хавсралтын дагуу мэдээг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Хороонд ирүүлж байхыг заасан.

Манай улсын хэмжээнд 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 190 ББСБ байгаагийн 99 нь буюу 52.1 хувь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бөгөөд үүний 49 нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, 50 нь банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Мэдээний ирц 2010 оны 1,2,3 дугаар улиралд 40.4% - 44.0% байсан бол 2010 оны 4 дүгээр улиралд 74.7%, 2011 оны 1 дүгээр улиралд 78.5% болж өмнөх улирлуудаас 30.7% - 38.1%-иар өссөн байна. 2011 оны 2 дугаар улирлын байдлаар мэдээний ирц 61.2% байна.

ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ВАЛЮТЫН ХАНШИЙН ТАЛААР:

Тайлант хугацаанд 4 ББСБ-д гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатай түдгэлзүүлж, 1 ББСБ-ын гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Гадаад валютын арилжааны мэдээ ирүүлсэн 53 ББСБ-ын 49 нь Улаанбаатар хотод, 4 хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. ББСБ-уудын гаргаж ирүүлсэн гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн нийт худалдаж авсан гадаад валют болон худалдсан гадаад валют бүрийн дүнг ам.доллар болон төгрөгт хөрвүүлж, хөрвүүлсэн дүнг 2010 оны 4, 2011 оны 1, 2011 оны 2 дугаар улирлын байдлаар харьцуулж дараах хүснэгтэд үзүүлэв. Үүнд:

1. Худалдаж авсан нийт гадаад валют:

/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

д/д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ IV улирал	2011 ОНЫ I улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/	2011 ОНЫ II улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/
1	ТӨГРӨГ	168,060,826.6	145,316,466.2	-22,744,360.4	196,156,917.3	50,840,451.1
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	132,278.3	116,268.1	-16,010.2	160,975.7	44,707.6
3	ДУНДАЖ ХАНШ	1,270.51	1,249.84	-20.67	1,218.55	-31.29

Дээрх хүснэгтээс үзэхэд худалдаж авсан нийт гадаад валютын төгрөгт хөрвүүлсэн мөнгөн дүнг 2011 оны 1 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 50,840,451.1 мянган төгрөг буюу 25.9 хувиар, 2010 оны 4 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 28,096,090.7 мянган төгрөг буюу 14.3 хувиар тус тус өсчээ. Харин ам.долларт хөрвүүлсэн дүнг 2011 оны 1 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 44,707.6 мянган ам.доллар буюу 27.8 хувиар өссөн, 2010 оны 4 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 28,696.4 мянган ам.доллар буюу 17.8 хувиар өссөн үзүүлэлттэй гарч байна.

Гадаад валют бүрийг худалдаж авсан нийт валютын ханшийг ам.долларт хөрвүүлж, ам.долларын дундаж ханшийг тооцож үзэхэд 1,218.55 төгрөг болж байна. Иймд үүнийг:

- 2010 оны 4 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 51.96 ам.доллар буюу 4.09 хувиар буурсан,
- 2011 оны 1 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 31.29 ам.доллар буюу 2.51 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Худалдсан нийт гадаад валют:

д/д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ IV улирал	2011 ОНЫ I улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/	2011 ОНЫ II улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/
1	ТӨГРӨГ	163,800,118.1	140,606,426.9	-23,193,691.2	237,093,710.9	96,487,284.1
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	128,875.0	111,713.0	- 17,162.0	194,131.0	82,418.0
3	ДУНДАЖ ХАНШ	1,271.0	1,258.64	-12.36	1,221.31	-37.33

Дээрх хүснэгтээс үзэхэд худалдсан нийт гадаад валютын төгрөгт хөрвүүлсэн мөнгөн дүнг өмнөх улирал буюу 2011 оны 1 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 96,487,284.1 мянган төгрөг буюу 40.7 хувиар, 2010 оны 4 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 73,293,592.8 мянган төгрөг буюу 30.9 хувиар тус тус өсчээ.

Ам.долларт хөрвүүлсэн дүнг 2011 оны 1 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 82,418.0 мянган ам.доллар буюу 33.6 хувиар өсч, 2010 оны 4 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 62,256.0 мянган ам.доллар буюу 42.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валют бүрийг худалдсан нийт валютын ханшийг ам.долларт хөрвүүлж, ам.долларын дундаж ханшийг тооцож үзэхэд 1,258.64 төгрөг болж байна. Үүнийг:

- 2010 оны 4 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 49.69 ам.доллар буюу 3.91 хувиар буурсан;
- 2011 оны 1 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 37.33 ам.доллар буюу 2.97 хувиар буурсан байна.

ББСБ-уудын 2011 оны 2 дугаар улирлын байдлаар худалдаж авсан гадаад валютын нийт дүнг худалдсан гадаад валютын нийт дүнтэй харьцуулж үзэхэд худалдсан гадаад валютын нийт дүн худалдан авсан гадаад валютын нийт дүнгээс 40,936,793.6 мянган төгрөгөөр буюу 17.3 хувиар их, 33,155.3 ам.доллараар буюу 17.1 хувиар тус тус их байна.

Гадаад валютын арилжааны мэдээ ирүүлсэн ББСБ-ын мэдээний нэгтгэлээс үзэхэд:

1. Худалдаж авсан нийт валютын 11.02%-ийг хуулийн этгээдээс, 88.98%-ийг иргэдээс худалдан авч;
2. Худалдсан нийт валютын 16.07%-ийг хуулийн этгээдэд, 83.93%-ийг иргэдэд тус тус худалдсан байгаагаас үзэхэд эдгээр ББСБ-ууд нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаагаар ихэвчлэн иргэдэд үйлчилж ирснийг харуулж байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаагаар нийт 433,250,628.2 мянган төгрөгийн буюу 355,106.7 мянган ам.долларын гүйлгээ хийгдсэн байгаагаас 45.3 хувь нь гадаад валютыг худалдаж авсан гүйлгээ, 54.7% нь гадаад валютыг худалдсан гүйлгээ байна.

ББСБ-уудын гадаад валютын арилжаанд түгээмэл ордог гадаад валютуудын ханшийг ам.долларт хөрвүүлж, дундаж ханшийн өөрчлөлт /хэлбэлзэл/-ийг 2010 оны жилийн эцэс 2011 оны 1,2 дугаар улирлын байдлаарх үзүүлэлтүүдтэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/төгрөгөөр/

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ДУНДАЖ ДҮН		
			2010 оны IV улирал	2011 оны I улирал	2011 оны II улирал
1	АНУ доллар	USD	1,271.00	1,254.24	1,219.93
2	Английн фунт	GBP	1,930.96	1,975.86	1,902.08
3	Евро	EUR	1,713.68	1,729.08	1,753.09
4	БНХАУ-ын юань	CNY	188.00	200.57	188.06
5	БНСУ-ын вон	KRW	1.04	1.16	1.23
6	ОХУ-ын рубль	RUB	41.20	43.54	42.87
7	Японы иен	JPY	15.50	15.63	15.04

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийг авч үзүүлвэл дараах байдалтай байна. Үүнд:

/төгрөгөөр/

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ /ӨСӨЛТ +; БУУРАЛТ -/		
			2010 оны IV улирал	2011 оны I улирал	2011 оны II улирал
1	АНУ доллар	USD	- 176.76	- 16.76	-34.31
2	Английн фунт	GBP	- 402.42	44.90	-73.78
3	Евро	EUR	- 18.53	- 21.09	24.01
4	БНХАУ-ын юань	CNY	- 400.90	15.40	-12.51
5	БНСУ-ын вон	KRW	-24.07	12,57	0.07
6	ОХУ-ын рубль	RUB	- 0.19	0.12	-0.67
7	Японы иен	JPY	- 6.40	2.34	-0.59

Дээрх хүснэгтээс үзэхэд 2011 оны 2 дугаар улиралд Евро 24.01, БНСУ-ын вон 0.07 төгрөгөөр тус тус өсч, Японы иен 0.59 төгрөгөөр, Оросын рубль 0.67 төгрөгөөр, Хятадын юань 12.51 төгрөгөөр, Английн фунт 73.78 төгрөгөөр, АНУ-ын ам.доллар 34.31 төгрөгөөр тус тус буурсан байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР